

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ: ДААЛИН УРЛАЛЫН АРГА ТЕХНОЛОГИ

Х. Ертөнц

ШУТИС, БУХС, Соёлын өв хамгаалал хөтөлбөрийн судлаач магистрант

yeroo_gs@yahoo.com

Д. Наранцацрал

Доктор (Ph. D.), дэд профессор

ШУТИС, БУХС, Хүмүүнлэгийн ухааны салбарын дэд профессор

narantsatsral5@must.edu.mn

Хураангуй: Ардын дүрслэн чимэглэх урлагийн бодит хэлбэр болох даалин нь монгол соёлыг олон зуун жилээр үеэс үед дамжуулан тээж ирсэн нэг гол хэрэглүүр болдог. Эртнээс нааш монголчууд нүүдлийн соёл иргэшилээ даган өөр хоорондоо харилцахдаа харц, үйл хөдлөл, биеийн хэлэмжээрээ олон зүйлийг өгүүлэн илэрхийлж байжээ. Үүний нэгэн илэрхийлэл болох монгол эрчүүдийн гоёл болох нэгэн гангараа нь даалин юм. Өвөг дээд маань үеэс үед удам дамжуулан өвлүүлэхийг хүссэн ахуйн эд өлгийн түүхэн дурсгал, өв соёл нь эдэлж хэрэглэж байсан бүхий л зүйлдээ нэвт шингэсэн өвөрмөц онцлогтой. Даалин урлал нь он цагийн уртад урлагийн бүтээл болтлоо хөгжин иржээ. Эхнэр хүн даалин бүтээхдээ хээ угалзыг бүтээх хатгамал нэг бүрт машид их ач холбогдол өгч бүхий л хайр хүндэтгэл, сайн сайхан болгоныг дотоод сэтгэлдээ нягт бясалган, төвлөрөн байж эрчим энергиэ шингээн урладаг байсан тул эзнийхээ хамаг л сүл хийморийг илтгэхийн сацуу хамгаалалт, энергийн уут болдог гэж ярьдаг. Эртнээс нааш уран бэрүүд болон айлын эхнэрүүд нь хань ижил, өрх гэрийн тэргүүндээ үнэнч хайрын бэлгэдэл хүндэтгэл болгон хөөрөгний даалин, мөнгөн аяганы уут, тамхины уут, хавтага зэргийг урлан өгдөг байв. Мөн буддын шашин дэлгэрэх үед сүм, хийд, шашны төвүүдийн захиалга машид эрчимтэй нэмэгдэж Энэтхэг, Түвд маягийн хийц монголын уран хатгамал, урлаг соёлд ихээхэн нэвтэрсэн байна.

Орчин цагт даалин урлан бүтээх нь мартагдаж буй маш олон төрлийн хатгамал, сүлжмэлийг олон нийтэд таниулан түгээх маш таатай боломжийг бүрдүүлж байна. Хатгамалчид уран бүтээлээ өөрийн гараар сайтар нягт нямбай туурвин урладаг. Тиймээс даалин урлах арга технологийг судласан болно. Одоогоор олон бие даасан чадварлаг урлаач нар төрийн бус байгууллага байгуулж хувийн урлан болон сургалтын төвүүд нээн ажиллуулж аажмаар мартагдан буй өв соёлоо олон түмэндээ түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлж байна. Нэг үеэ бодоход даалин урлаж сурах хүсэлтэй хүмүүс маш их байгаа нэн сайн юм аа. Иймд “Уран хатгамал/Emroidery” цахим сүлжээний группээр онлайн хичээл явуулж олон түмэнд хүргэх зорилготой байгаа билээ.

Түлхүүр үгс: Уран хатгамал, бэлдэц, зүү ороох оёдол буюу эрхээмэл хатгамал, хөөмөлтэй зүү ороох.

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Соёлын өвийг дотор нь биет болон биет бус өв гэж хуваадаг. Биет бус өв гэдэг нь товчоор хэлбэл хүний оюун ухаанаар бүтээгддэг, үеэс үед сургаж дамжин үлддэг зүйлийг хэлнэ. Ийм нэгэн өвийн төрөл бол даалин урлал юм. Энэ өв нь соёлын биет бус өвийн Ардын уламжлалт гар урлалын төрөлд хамаардаг. Манай ард түмэн түүхийн бүхий л хугацаанд үр хүүхэд хойч үедээ үндэсний уламжлалт ардын гар урлалын дуусашгүй өв сангаас зааж сургаж түүний арга ухааныг дамжуулан ирсэн баялаг түүхтэй билээ. Нутаг нуггийн

онцлогоос хамааран хувцас, эд юмсыг зохион бүтээх, урлах, чимэглэн бүтээх арга нь өөр өөр байдаг.

Гар урлалын төрөл болох уран хатгамал нь олон төрөл байдаг бөгөөд тус бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтой байдаг. Хатгамалын сэдэв нь хүн төрөлхтний түүхэн хөгжилтэй нягт холбоотой учир он цаг улиран өнгөрөх тусам өөрчлөгдөн хувирч иржээ. Уран хатгамалыг хээ угалзаар чимэглэхээс гадна амьтан, ургамал, ус, газар орон, хүний хөрөг болон бодит амьдралын байдлаас эх авч, нийгмийн ахуйг уран сайхнаар дүрслэн үзүүлдэг гэж хэлж болно.

Ном судраас хатгамалын түүх, уламжлалыг нь судлах явцад “Уран хүн ирвэл учиг нэмнэ Улцан хүн ирвэл нулимс нэмнэ”, “Үйл бүтээхэд уран хүн Үг бүтээхэд сэцэн хүн” гэх зэргээр уран бэрийн торгон ухаан, эмэгтэй хүний мяндасан ухаан гэдэг тэр бүхэн үйл урлалаас л төрж байжээ гэж дүгнэж болохуйц. Гар урлалын төрөл болох уран хатгамал нь дотроо олон төрөл бөгөөд тус бүр өвөрмөц онцлогтой байдаг.

Даалингийн хэмжээс нь бага, дунд, их гарын гэж ангилагдах ба 26-54 см байдаг. [1] Орчин үед бараа таваар элбэг болсон тул үүнд хэрэглэгдэх бүтээгдэхүүн болох материал (пүсү, минчү, чисчү, торго гэх мэт), 120/D, 135, 150/D дугаар бүхий 30-260 ширхэгтэй хатгамалын утас болон зүү (но.7/8/9/10/11/12 бүдүүн, нарийн)-гээ сонгон уран бүтээлч өөрийн мэдрэмжинд тулгуурлан сонгосон хээгээ зураачаар зуруулж бэлдэц болгон авна. Бэлдэцэнд бага, дунд жижиг гарын даалин, мөнгөн аяганы уут, даллага уут, хавтага, тамхины уут, малгайн залаа, монгол гутлын оймсны хараа, дээлийн зах, ханцуй, хантаазны хээ болон янз бүрийн гоёл чимэглэлд өргөн хэрэглэж байна. Тэр тусмаа уран хатгамалын үйл нь хатгамалч хүн өөрийн гараар хээ угалз тус бүрийг нэг бүрчлэн завсар зай гаргалгүй нэгэн жигд, нягт нямбай цэгцтэй урладаг бөгөөд тухайн бүтээлд нь манай ард түмний баялаг түүхт уламжлал, бэлгэдэл гоо зүй, өнгө дүрсийн зохилдоо бүрийг тусгайлан сэтгэчилж бүтээдэг учир олон төрлийн мэдлэг мэдээлэлийг давхар олдог байна. Мөн хатгамал хийх явцдаа хүн маш их төлөв түвшин байж тэвчээр хатамжтай суун аливаа асуудлын гарц гаргалгаа, шийдлийг олох эрэл хайгуулыг дотоод сэтгэлдээ эрэлхийлхийн хамт нөгөө талдаа хувь хүнийг төлөвшүүлэх, хүмүүжүүлэх, хөгжүүлэхдээ илүү үр нөлөөтэй байсан байна. Эртнээс нааш ухаант өвөг дээдэс маань хойч үеэ үг яриагаар бус үйл хөдлөлөөр дагуулан “Хүнээр хүн хийх” агуу ухааныг уламжлалт сургалт хүмүүжлийн арга үйлэндээ ихэд нэвтрүүлсэн байдаг үйл урлах сургалт үүнийг нэгэн тод илрэл болж байна. Шинжлэх ухаан үүнийг нотолж сэтгэл судлалын салбар дахь эмчилгээний төрөл нь уран хатгамалаар эмчлэх арга болж байна.

“Нийгэмд бидний сэтгэл зүй маш их гэмтэж байна. Бид сэтгэлийн түршүүр стрессээ тайлах хэрэгтэй, үүний тулд бидэнд үзүүлэх зүйл байх ёстой гэж бодож байна. Хатгамалын гар урлал нь биднийг бүсчилж өөрт ашигтай зүйл хийх боломжийг олгодог. Энэ нь таны дотоод сэтгэл, зөн совинтой холбодог. Оёдолын давталттай, хэмнэлтэй хөдөлгөөн нь сэтгэл ханамж төвлөрөлийг бий болгодог. Энэ нь үнэндээ тархины бүтэцийг өөрчилдөг. Бүтээлч ажилд анхаарлаа төвлөрүүлснээр стрессийн дааврын кортизолийн түвшин буурдаг” [2] Иймд бид хүмүүст үйл урлах эрдэм ухааныг аль болох түгээн дэлгэрүүлж зааж сургах ажилд илүүтэй анхаарлаа хандуулж байна.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Манай оронд үйл урлал хөгжсөн түүхийн ул мөрийг тодруулах гол баримт нь Төв Ази болон Монголын түүх соёлыг судалсан судлаачид, аянчин жуулчдын бүтээл тэмдэглэлд багагүй зүйл тусгагдан орсон нь түүхийн чухал баримт болж үлджээ. Монголд үйл урлал үүсэн хөгжсөн түүхэн уламжлалыг тухайлан судалж нэгтгэсэн зүйл одоохондоо хомс ч тус оронд хувцас, эдлэл хэдүйд үүссэн түүхийг судалсан судлаачид тухайн орны газар шороон дээр хүн суурьшсан, байгаль цаг уурын нөлөөтэй холбон үзсэн байдаг. [3]

Одоогоос 100 мянган жилийн өмнө хойд туйлаас сэрүүн уур амьсгал орж улмаар мөстөлт болж зарим газар 2 метр зузаан мөсөн бүрхүүл болох үед сэрүүн уур амьсгалд зохицохын тулд хүн хувцас эдлэл хэрэглэх болсон гэж үзжээ. Байгаль өөрчлөгдөх явцад сэрүүн уур амьсгал хүний биед мэдэгдэхүйц нөлөөлжээ. Түүнд зохицохын тулд өөрт заяасан үс арьсаар амьдрах нөхцөлгүй болж ургамлын зүйл, ан амьтны арьсыг нөмрөх, дэвсэх, хучиж хулдах зэргээр ашиглаж байсан аргаас ангийн арьсыг нөмрөн хоёр талыг нүхлэн гартаа углан тогтоох, араасаа нөмөрч урд хоёр годыг эгэмийн орчим уяж холбон зангидах зэргээр тогтоох аргад шилжсэн нь тухайн үедээ дэвшилтэт арга байжээ. Эдгээр нь дулаанд ашигтай ч хөдөлмөрлөхөд тээртэй байснаас түүнийг хувцас хэлбэрт анхны загвар үүссэн байж таарна. Сэдэж бүтээсэн загвараа эсгэн огтлон зүсэж эхэлсэнээс хувцас, эдлэлийн эсгүүр бий болжээ. Эсгэж бэлтгэсэн эд ангийг эвлүүлж оёх, холбож үдэх зэргээр нэгэн хувцас болгосон үеэс оёдлын төрлүүд үүссэн бололтой. Хүний нийгмийн дэвшил хөгжлийн түүхэн үе шаттай холбож үдэх зэргээр нэгэн хувцас болгосон үеэс оёдлын төрлүүд үүссэн. Хүний нийгмийн дэвшил хөгжлийн түүхэн үе шаттай холбож үзэхдээ манай гараг дээр болсон гэжээ. Энэ үед амьтны гаралтай ноос үс, ургамлын гаралтай олс, маалинга мэт ширхэгт ургамлыг нэхэх, сүлжих, ээрэх, эрчлэх томох зэрэг аргыг сурч хувцас эдлэл урлах болсон нь үйл урлалын болон бөс бараа үүсэн

хөгжих суурь тавигджээ. [4] Үйлийн багаж хэрэгсэлийн мэдэгдэж байгаа баримтыг дурьдвал археологийн судалгаагаар багагүй зүйл олдсон байна.

Уйгарын үед гар урлалын нэг салбар болсон оёдол үйлэнд дэвшил гарсаны жишээ нь, урлалын өнгө, чимэглэлд тод, улаан өнгийг голлон хэрэглэдэг, хээ угалзанд үүл, усан хээ, газар дэлхийн гоо зүйг тодруулан цэцэг, навч, эвэр угалз геометрийн хээг өргөн хэрэглэдэг байжээ. Чимэглэлд хээ угалзыг товойлгон, хотойлгох, тахир шулуун, долгиотой, хагас дугуй хэлбэрээр хээлдэг байсан нь уран үйлэнд гарсан дэвшил юм.

Хятаны үед гар урлалын нэг төрөл болох нэхмэлийн гар ажиллагааг механикжуулж оньсон сууриар нэхмэл нэхэх, үйлдвэр байгуулжээ. Үүнээс үзэхэд уран үйлийн төрөл механикийн төрөлжсөн үйлдвэртэй, түүнийг удирдах улсын чанартай байгууллагатай болсон нь ихээхэн дэвшилт байжээ.

XIII зууны үед феодалын харилцаа гүнзгийрч байсан ч гар урлалын төрлүүд тасралтгүй хөгжиж асар их дэвшил гарчээ. Монголчуудын аж амьдрал урьдаас уламжлагдаж мал аж ахуй голлосон хэвээр байсан тул эсгий гэр, арьс ширэн хувцас эдлэл голлон байжээ. Харин гадаад харилцаа өргөжиж торго, бөс даавуун хувцас элбэгшин, оёдол хатгамалд шинэ дэвшилтэт арга нэвтэрч нэр төрөл нь олшрон хатгамалын бүх төрлүүд хийгдэж байжээ.

Ардын гар урлал өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй хөгжихөд саад болж байсан бас нэгэн төвөгтэй зүйл нь тухайн үед гаднаас нэвтэрсэн шашныг дагаж Энэтхэг, Төвд маягийн урлаг нэвтэрч байсан боловч үндэсний давтагдашгүй өвөрмөц урлаг өөрийнхөө шинж чанарыг хадгалсан, нүүдлийн аж амьдралын нөхцөлд дээд зэргээр тохирсон гоо зүй, өнгө үзэмж, хээ чимэглэл, гэрэл гэгээ, хөдөлгөөнийг харуулсан энгийн мөртөө бодитой, гайхмаар урлаг хөгжиж байж. ХҮI зууны үед гар урлалын нэгэн төрөл болох зээгт наамал, хатгамалыг үнэт эрдэнэсийн зүйлээр чимэглэн бүтээсэн торго, хялгасан эд, элдэв үнэт хоргой, саагаар бүтсэн олон янзын хийцийн бурханы хөргүүд эдүгээ бидний үед уламжлагдан үзмэрийн газар хадгалагдаж байна. [5]

ХҮI зууны үеэс буддын шашны төвүүдийн дэргэд оёдолчин, хатгамалчин, хээлж чимэглэх урлагт дадлагажсан үйлчдийг цуглуулан суулгаж нэгдсэн журмаар урлан бүтээдэг байжээ. Иймээс зээгт наамал бурхан шүтээн, хаад ноёдын зуны гэрийн торго, бөс барааны урлалын хээ чимгийг хийхэд нааж цардах, хээлж чимэглэх, зээг даруулах, хээ хайчлах зэрэгт тус бүрд нь мэргэжсэн урлаачид урладаг байжээ. Энэ уламжлал XIX зуун хүртэл үргэлжилж ирсэн байна. ХҮI зууны үед тус улсын феодалын зардал эрчимтэй явагдаж байсан ч ардын гар урлал тасралтгүй их, бага хэмжээгээр явагдаж байв.

Эзэн Чингисийг залгамжлагчид хоорондоо байлдан тэмцэлдсээр их Монголын төрийг сулруулсан боловч Мөнх хаан өөрийн дүү Хубилай хаанд

Долнуураас холгүй өргөө байгуулах зарлиг буулгажээ. Мөнх хаан дайны талбарт нас нөгчисний дараа 1260 онд Хубилай хаан ширээнд сууж 1267 онд (Жүндү) хотын суурин дээр нийслэлээ байгуулж бусад хотоос ялгахын тулд “Их нийслэл” гэж нэрлэн байснаас хожим нь Бээжин гэж нэрлэжээ. Тэр үед Юан улсын хүн амыг 10 зэрэгт хуваасны нэг нь гар урчууд байжээ. Пэрлэйсамбуугийн бичсэнээс үзвэл, Юан улсын үед албаны олон жижиг үйлдвэрүүдийн зэрэгцээ айл өрхийн ахуйн хэрэглээний зүйлийг урлах урлаачид байжээ. Энэ үед төвлөрсөн хот балгас олширч хүн амын цөөнх хэсэг сууршин жижиг гар үйлдвэрүүд эрхлэх болсон нь ахуйн хэрэглээний зүйлийг урлан бүтээхэд нөлөө болжээ. Тэр үед монгол үйл урлалын гол түүхий эд урьдын адил малаас гаралтай арьс шир, ноос үс байсан ч гадаад харилцаа өргөжин торго, бөс бараа элбэгшиж байсан нь үйл урлахад дөхөм болжээ. 1298-1328 онд нийслэлийн (Бээжин) дотор дархан мужаан, эсгийчин, арьсчин гэх мэт хамтран ажилладаг бүлэг хүмүүс байсан нь арьс шир, эсгийн урлал хөгжихөд нөлөөлжээ. [6]

Монгол үндэстний олон жилийн түүхэн өв уламжлалын өнгө төрхийг ардын гар урлалгүйгээр төсөөлөхийн аргагүй. Нүүдэлчин Монголчууд бид соёл иргэншлийн онцлогоосоо шалтгаалан гар урлалыг өдөр тутмын амьдрал ахуйдаа хэрэглэхийн зэрэгцээ тэдгээрийг урлаг болтол хөгжүүлж ирсэн түүхэн уламжлалтай. Бидэнд өвлөгдөн ирсэн ардын их өв соёл ч гар урлалтай салшгүй холбоотой. Монголд гар урлал анх үүссэн цаг нь хөдөлмөрийн багаж зэвсгээ хийж эхэлсэнтэй холбоотой. Ялангуяа мал маллагаа, ахуйн хэрэглээнд гар урлалын бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлага их байсан нь түүний хөгжих нөхцлийг бүрдүүлсэн байдаг. [7]. Монгол эмэгтэйчүүд ихэнхдээ өөрсдийн хэрэглээний малгай, дээл хувцас, гутал болон гэр ахуйн хэрэглээний эд зүйлсээ гараар оёх, хатгамал хийх, дээс томох, сүлжих, эсгий ширдэг хийх зэрэг ахуй амьдралдаа өдөр тутамд хэрэглэдэг зүйлсээ гараар урладаг байсан. Айл гэрийн эзэгтэй бүхэн хамгийн наад зах нь гэр бүлийнхэндээ дээлийг нь оёод, гутал хийгээд өгчихдөг байсан нь эмэгтэй хүн бүр утас зүү нийлүүлэн урлал хийдэг байсныг илтгэнэ.

Дээрх бүх өдөр тутмын ахуйн хэрэглээний зүйлсийг хийхээс гадна урлагийн бүтээл болохуйц уран дарханы хийсэн ээмэг бөгж, эмэгтэй хүний толгойн боолт, үсний гоёл, мөнгөн аяга, эрэгтэй хүний бүс, малгайн гоёл, үнэт чулуун хөөрөг, уран гартай бүсгүйчүүдийн урласан гоёлын болон баяр ёслолын үеэр хэрэглэх үнэ цэнэт бүтээлүүдийг олон төрлөөр урладаг байсан. Ялангуяа уран дархны бүтээлүүд, монгол зураг, сийлбэр зэргээс гадна уран эмэгтэйчүүдийн хувьд уран хатгамал, зүү ороох оёдол, зоос ширээ сүлжмэл, зээгт наамал зэргээр оёж хатгасан ховор нандин урлагийн бүтээлүүд олон. [8]

Монголчууд малынхаа ноос, арьс, шир болон эсгийгээр эд зүйлс урлахын зэрэгцээ бөс даавуу, торго дурданг түгээмэл хэрэглэж, оёмол, хатгамал, ширмэл, наамал урлалыг хөгжүүлж ирсэн түүхтэй. Дээл хувцас, малгай, гутал, оймс, хавтага, бэл, хэтэвч, даалин, гаансны уут, аяганы уут зэргийг олон өнгө хоршуулан ур гарган шаглаж, хатгаж, зүү ороож, зээг тавьж, уран нарийн хийцтэй, ховор нандин эд зүйлсийг урлаж, өв соёлоо тээн хөгжүүлж иржээ.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Хөөрөг бол урлаг, соёл, зан заншил, өв, үнэт эдлэл гэсэн ойлголтуудын нэгдэл бөгөөд чулуугаар хийсэн урлагийн бүтээл юм. Монголчууд хөөргөндөө даалин хэмээх монгол ур ухаан шингэсэн уран нарийн оёдол хатгамал хийцтэй утга билгэдэл төгс уутыг бүтээсэн байна. Хөөргийг нандигнан, сайхан урласан даалин, уутанд хийж эрхэмлэн дээдэлж ирсэн уламжлалтай. [9]

Монголчуудын хөөрөгний хэрэглээ сүүлийн үед ихэсч, ахмад настнууд, өрх гэрийн тэргүүн, ер нь хүн бүр хүүхдүүдэд хүртэл эцэг эх нь хөөрөг бэлдэж өгдөг, түүндээ тохирсон даалин оёдог болжээ.

Хөөрөгний даалин нь нутаг нутгийн онцлог, авч явах хэрэглээнээсээ хамааран янз бүрийн хэмжээтэй байжээ. Дээр үед эрэгтэйчүүд алс хол явах, аян жин тээх, ямба ёслолын үед даалингаа зүүн ташаандаа, бүсэндээ хавчуулан зүүж явдаг уламжлалтай байсан бөгөөд тэр үеийн даалингийн хэмжээг харахад нилээд урт 44-46 см өргөн нь 18-19 см орчим хэмжээтэй байна.

Орчин үед даалинг бүсэндээ зүүх нь ховор, ямар нэг үндэсний хувцасны өдөрлөг, үзүүлбэр үзүүлэх үеэр иж бүрэн хувцаслахаас гадна бүсэндээ даалин, хэт хутга зүүсэн харагддаг. Мөн зарим кино жүжгийн тоглолтонд уламжлалт үндэсний өв соёлоо нээн харуулж бусдад ойлгуулан таниулдаг байна. [10]. Хөөрөгний даалин урладаг олон урчуудтай уулзаж ярилцахад даалин оёх материалаа 25*25 см, 30*30 см, 35*35 см хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй эсгэж оёдог аж. Эдгээр хэмжээг даалингийн хээ оёод эмжээргүй байгаагаар тооцвол урт нь 25 см өргөн нь 12,5 см, урт нь 30 см өргөн нь 15 см, урт нь 40 см өргөн нь 20 см хэмжээтэй даалин болох юм. Энэ хэмжээн дээр хоёр захын эмжээр 6-8 см нэмэхэд урт нь 31-33 см өргөн нь 12,5 см урт нь 36-38 см өргөн нь 15 см, урт нь 41-43 см өргөн нь 20 см хэмжээтэй даалин болно. Ер нь өөрийнхөө хөөрөгний том жижиг, чулууны үнэ цэнэ зэрэгт зохицуулан ямар хэмжээтэй даалин захиалах нь хүмүүсийн өөрсдийн сонирхол болжээ. Цөөхөн тохиолдолд 40-40 см хэмжээтэй материалаар даалин захиалдаг ба бүсэндээ хавчуулах даалинд урт нь өөрчлөгдөж 45-40 см болдог байна.

Гэхдээ газар газрын ёсонд даалингийн өргөн нарийн, урт богино нь янз бүрийн хэмжээтэй байдаг.

Даалин урлалын арга технологи, дизайн. Зүү ороох хатгамлын үүсэл гарал нь нарийн тогтоогдоогүй. Анх гал хэрэглэж эхэлсэн үеэс эхтэй гэж үздэг. Гал асаахын тулд модоо үрж эндээс анх гогцоо үүсчээ. Судлаачид уран хатгамлыг XIX зуунд нүүдэлчдийн амьдралын өдөр тутмын хэрэглээнээс хальж, урлаг болтлоо хөгжсөн гэж үздэг. Хаад ноёд, хатдын дээл хүрэм, ууж, гуталд чимэг гоёл болгон оёдог болсноос гадна энэ төрлөөр дагнасан уран хатгамалчид ч бий болсон. Даавуу даалимба, торгон дээр зүү ороож байснаа булигаар, арьс шир, эсгийн дээр ч зүү ороох болсон түүх бий. 32, 64 угалзтай гутлын шагай, түрий, оймсны хараа, гөлөм зэрэг дээр монгол бүсгүйчүүдийн зүү ороох урлал нь түүх болон үлджээ.

Зүү ороох хатгамал нь монгол угсаатны эртний уламжлалт урлагийн дээжист хадгалаастай төдийгүй түүнийг орчин үеийн гол чимэглэлийн урлагт ч уламжлан хэрэглэсээр байна. Төрөл бүрийн зөөлөн эдлэл, тухайлбал торго торгомсог бөс даавуугаар урлах урлалын нэг бол уламжлалт зүү ороох оёдол юм. Энэхүү арга нь халхчуудын дунд ихэд түгээмэл тархсан төдийгүй хийж гүйцэтгэх арга талаасаа ч нийтлэг нэг аж. Харин түүнийг нэхлэх нь хийх аргын өвөрмөц талаас нь ухаарсан “эрхээмэл хийх”, “зүү ороох”, “угалз ороох” зэргээр харилцан адилгүй нэрлэх боловч эдгээрээс “зүү ороох” гэх нь халх ястны дунд ихэд дэлгэр ажээ.

Ардын урлаачид энэ аргаар төрөл бүрийн хээ угалз, ялангуяа олон өнгө солонгоруулан дагнасан геометр гарлын хээ угалзыг ихээхэн хийдэг төдийгүй, энэ нь хийх арга талаасаа ч нэлээд тохиромжтой байдаг бололтой. Тухайлбал: оймсны хараанд судсан хээ, эвэр угалз, төрөл бүрийн өлзий, хатан сүйх, хаан бугуйвч мөн давхар алх, олон янзын сүлжээ, хоршоо, цаасан хүрээ, гөрөлгөө гэх мэт хээнүүдийг хийхээс гадна хөөрөгний даалин тамхины хавтага, нүдний шилний гэр, хэтэв, бэл, хавтага, чихэвч, гаансны дугтуй, эрэгтэй хүний төрөл бүрийн малгайн оройн хээ, залааны угалз гэх зэрэг гоёлын зориулалт бүхий хувцасны нэмэлт чимэглэлийг ихэвчлэн зүү ороох аргаар хийж байжээ.

Халхад айл гэрийн эзэн хүн алс хол ажлаар явахдаа мөнгөн аягаа гоё сайхан аяганы уутанд хийж түүнийгээ баруун ташаандаа зүүж явдаг уламжлалтай. Үзэмжтэй хийсэн аяганы алчуур дан ганц ахуйн зориулалттай төдийгүй, гоёлын гэсэн хос шинжийг илтгэж байжээ. [11]

Зүү ороох оёдлыг дан ганц эдлэл хэрэглэл, хувцас хунарын зүйлд өргөн хэрэглээд зогсохгүй, бурхан шашны зориулалт бүхий зарим эд юмсыг гоёж чимэглэхэд гол арга болгон ашиглаж байсан бөгөөд энэ аргыг эрхлэгч хэн боловч тусгайлан бэлдсэн урлах газар шаарддаггүй гэр зуур эмэгтэй хүн үндсэн ажлаа хийх зав чөлөөгөөрөө эрхлэн явуулхад бүрэн нийцсэн зэрэг нь

ихээхэн өвөрмөц талтай. Мөн нүүдлийн мал аж ахуйн соёлын хэв шинж тогтолцоотой нягт уялдаж энэ үндсэн дээр бүрэлдэж буй болсон арга гэж болно.

Монгол хүний оюун ухаанаар бүтсэн хатгамлыг бурхан шашны эд зүйл, хөөрөгний даалин, аяганы уут зэргээс харж болно. Оёдол урлалын охь болсон энэхүү зүү ороож урласан зоосон сүлжмэлээр даруулж загасан нуруугаар битүүлсэн даалин урлал гэдэг бол зөвхөн монгол эмэгтэйчүүдэд л өвлөгдөж үлдсэн манай монголын биет бус өв соёлын нэг. Ялангуяа эцэг өвгөдөөс дамжиж ирсэн аливаа зүйлд тухайн үр хүүхэддээ өв уламжлал болж үлдэхээс гадна ижий аавтайгаа ойр дотно байгаа юм шиг мэдрэмжийг өгдөг. Жишээ нь аяганы уутан дээр байгаа найман хэрээст хорол эрдэнэ гэхэд бурханы найман тахилын нэг учир шигтгэж урлахад 1068 удаагийн зүү орооно. Энэ бүхнийг урлаж суухдаа мэдээж тухайн хүнд бүхий л эерэг энергийг аяганы уутандаа шингээдэг учраас энергийн уут болж үлддэг. Даалинг ч гэсэн хамгийн том хүндлэл, хүний сүр сүлдийг авч явдаг учраас энергийн уут гэж ярьдаг. Монгол бүсгүйн ур ухаан, хайр сэтгэл, зүрхээ шингээн байж урласан энэ гайхамшигт зүү ороох урлал дэлхийд ганцхан л хувь юмдаа. [12]

Зээгт наамал, задгай утсан хатгамал зэрэг торгомсог эдлэлээр урлаж бүтээдэг уламжлалт аргуудтай харьцуулахад халхчуудын дунд ихээхэн нийтлэг тархацтай олныг хамарсан шинжтэйгээр ялгаатай юм. Энэ чанараараа даруй халхын гар урлалын соёлын нийтлэгийг ямар нэг хэмжээгээр тодруулах гэрч өгнө.

XVIII-XIX зууны үед зүү ороох оёдлоор бурхан тахилын зүйлийг оёхдоо бумбыг улаан шараар, загасыг шараар битүүлэн гадна талаар нь саа даруулан, мушгирсан бүч доод угалзыг нь улаан ногооны төрлийн дагнан шар саагаар даруулж оёсон тухай О.Өнөрмаа бүтээлдээ дурьджээ. [13] Эдгээрээс ажиглахад зүү ороох оёдолоор хээ угалзыг оёод зогсохгүй янз бүрийн амьтан, сав суулга, цэцэг навчийг тухайн эдлэлдээ тохируулан урлаж байжээ.

Халхчуудын зүү ороох аргаас үзвэл хийх зүйлийнхээ хэлбэр хэмжээ, түүн дээр байх хээ угалз, тэдгээрийн өнгө зохицол, хэрэглэгдэх материал зэргийг юуны өмнө сайтар нягтлан бодсон байна. Зарим тохиолдолд хийх зүйлээ бэлэн болсон байдлаар өнгө ялган зурж хийж байх үедээ мөрдлөг болгон ашиглах явдал ч бий. Юуны өмнө хийж байгаа зүйлийнхээ аль хэсэгт нь юун хээг ямар хэмжээ харьцаагаар хийхээ урьдаж цаасан дээр зохиомжлон хараар зурж бэлдэнэ. Үүнийгээ гэрэлтдэг нимгэн цаасны тусламжтайгаар харандаагаар тодруулан буулгаж аван зүүгээр ойр ойрхон шивж цоолон хээгээ буулгаж загвар болгон ашиглана. Энэ байдал нь манай уламжлалт гар урлалын дарх мод, наамлын гэх мэт төрлүүдийг урлах аргад байхаас гадна нүүдэлчдийн гар урлалын урлах арга барилын нэг онцлог хэсэг юм. Үүний дараагаар зүү

ороох дэвсгэр материалаа бэлдэж янзална. Төрөл бүрийн хээгүй, цулгуй торго байвал тохиромжтойн дээр илүү гоёмсог гэж үзэх энэ уламжлалт аргаар урлах өвөрмөц онцлогтой уялдаж зүү ороож хээ тавих тэр хэсгийг бие оруулж өгөх шаардлагатай байдаг. Үүнийг урлаачид нилээд хэдэн янзаар гүйцэтгэж иржээ. Тухайлбал: Хээ угалз тавих тэр хэсэгт цаваг барьж наах, эсвэл нийтэд нь жонхуудаж бие оруулах, мөн ард нь нимгэн цаас муутуу нааж өгөх зэрэг болно. Ингэж бэлдсэний дараагаар шивж цоолж бэлдсэн хээ угалзаа товолсон газар нь байрлуулан тод өнгийн нунтгийг нимгэн даавуунд боон арчих журмаар буулган авна. Гарсан тэр хээгээ лавшруулж тодруулан эцэст нь зүү ороох ажлаа эхэлж зүү ороох утас бүдүүн нарийнгүй нэгэн жигд бас эрчний чанга сул бүгд адил, торго мяндсан утас байвал хийж буй зүйл үзэмжтэй болохын нэг үндэс гэж үздэг байжээ. Ер нь утас хэдийчинээ нарийн байх нь хийж буй зүйл төдийчинээ цэвэрхэн үзэмжтэй болдог. Харин ихээхэн ур дүй чадвар шаардагддаг байв. Зүү орооход хоёр утас хэрэглэгддэг, нилээд тохиолдолд хоёр утасны өнгөний утас солгой, доод талын буюу ороосон утсыг шаглаж холбох утас зөв эрчтэй байна.

Эрдэмтэн Э. Чимэдцэрэнгийн бичсэнээр "... Нэг утсыг зүүндээ сүвэлж зургийн эхнээс дороос дээш нь хатгаж зүүнийхээ үзүүрийг гаргаад нөгөө өнгөн дээр гаргаж орхисон утсаараа зүүгээ нэг ороож, зүүгээ татаж гаргаад зүүний хэмжээгээр жижиг дугуй гарган ар руу нь буцааж нэвт даруулан оёод, зүүгээ дахин буцааж дээш хатгаж гарган гэдрэг эргүүлж урд гаргасан нөгөө дугуйтайгаа холбон гэдрэг даруулж оёх зэргээр үргэлжлүүлэн оёно. Энэ мэтээр хээний нэг дагнаасыг утас таслалгүйгээр бүрэн дуусгаж оёсны дараагаар өөр өнгийн утас хүрэлцэхүйцээр сүвлэж дараагийнхыг оёх зэргээр давтагдана. Харин утасны чанга сул, өөрөөр хэлбэл таталтыг нэгэн жигд байлгах, мөн түүний хатгалт, алхмын хол ойрыг нэгэн жигд зөв тохируулж байх явдал уг ажлыг гүйцэтгэж байх үед чухлаар мөрдөгдөх төдийгүй хийж буй зүйл гоё сайхан болох нэг нөхцөл гэж үздэг аж.

Монголчууд дээр үеэс шинэ ирсэн бэрээ хадам талдаа идээшин, шинэ амьдралд дастал нь гэж зүү ороолгож суулгадаг байсан гэж хуучцуул ярьдаг. Ер нь даалин урлал гэдэг бол аав ээждээ, найздаа гэх мэт хамгийн ойр дотны хүндээ зориулагдаж хийж байдаг. Тэгэхээр аль өнгө нь тухайн хүнд зохицолтой байдаг дээрээс нь ямар торгон дээр яаж оёх вэ тухайн хүний нас сүүдэр, ажил мэргэжил, онцлогоос хамаараад хээг яаж тусгаж өгөх вэ гээд их олон нарийн ухаан шаардаж байж нэг бүтээл бүтдэг. Олон цагаар уйгагүй суудаг эмэгтэй хүний нандин мэдрэмжийг хөгжүүлдэг урлал юм.

Бидний өвөг дээдэс өөрийнхөө аягыг аяганыхаа даалинд хийгээд аваад явдаг байсан. Айлд орохдоо өөрөө аягаа гаргаад цайгаа уучихдаг. Энэ нь ариун цэврийн хувьд мөн эрүүл мэнд, өв соёлынхоо хувьд ч нандин зүйл болдог.

Тиймээс хэдэн үеэрээ дамжиж, он цагтаа уусан шингэж, үнэт өв болон хадгалагддаг.







Одоо техник технологи хөгжөөд янз бүрийн даавуун дээр хэрээсэн, ширсэн гээд олон янзын оёдлууд байна. Харин зүү ороож хийсэн оёдол бол машинаар оёж байгаа оёдлуудыг бодвол харьцангуй эдэлгээ удаан, олон жил үе дамжиж үлддэг өв гэдгээрээ өөр. Тиймээс утас ч гэсэн тодорхой хэмжээнд чанартай байх хэрэгтэй. Уран хатгамалчдын оёдол хийж байгаа утас бол 120/2D юм. Аяганы даалингийн тээг гэж бий. Тээгийг хаш чулуугаар хийдэг.




Зүү ороолт нь жинхэнэ манай үндэсний уламжлалт төрөл хатгамал ба аливаа эдлэл хэрэгцээний зүйлийг чимэхдээ маш бат бөхөөрөө онцлогтой. Уул юмны дэвсгэр нь элэгдээд урагдахад зүү ороосон хээ угалз нь үлддэг гэдэг байжээ. Эрт дээр үед “маажин утас” гэдэг нарийн торгон утсаар ороодог байсан байна.

Ардын урлаачид зүү ороох аргаар ижил төстэй зохицоо сайтай олон өнгийг хүндээс хөнгөнд шилжүүлэх замаар хээ угалзыг хийж буй зүйлийнхээ дэвсгэр өнгөтэй өнгө ялгаруулан оёдог уламжлалтай. Энэ нь тухайн урлаачийн урлах арга ухаан, уран чадвараас шууд шалтгаалах онцлогтой боловч ажиглалтаас үзхэд хээ угалзны өнгө хосолсон дагнаасуудыг зүү ороож хийхдээ 3-5 зэрэгцүүлэн хийсэн нь түгээмэл үзэгдэж байна. Зүү ороох оёдлоор малгай чимэглэх нь олонтаа байдаг. Нилээд тохиолдолд хээ угалзны дагнаас, өнгө хоршсон ерөнхий байдал тогтож хэвшсэн гэж болно.

Тухайлбал хөх ногоон эсвэл улаан ягаан, ногоон төрлийн өнгөгүүдээс хүндээс хөнгөнд шилжүүлэх журмаар дагнаж хийдэг байжээ. Жишээ нь: хээг дагнан улааны төрлийн өнгөөр өнгө хослуулж дагнана гэж үзвэл хамгийн дотор талд хүрэн улаан, түүний гадна улаан, тэгээд улаан ягаан, цайвар ягаан, цагаан гэх мэт. Энэчлэн өнгийн зохицоог зөв тохируулахаас гадна зүү ороож буй утасны чанар, өнгө, эрчний сул чангаас шалтгаалан уг хийж буй зүйлийн чанар, гоо сайхан тодордог.

Зураг 1. Зүү ороох оёдлыг оёх дараалал

№	Зураг дүрслэл	Оёх дараалал
1		<p>Зүү ороох утсыг улаанаар үзүүлэв. А. Зүүгээ оёх хээнийхээ үзүүрээс ар талаас өнгө рүү хатган гүйцэт татаж гаргаад сул орхино.</p>
2		<p>Хатгасан утаснаас 1мм зайд шаглах утастай зүүгээ дороос дээш хагас гаргана. Шаглах утсыг цэнхэрээр үзүүлэв.</p>
3		<p>Дээш гарсан зүүг өнгөн дээр байгаа утсаараа зургийн дагуу ороож, зүүн гарын эрхий хурууны хумсаар хөдөлгөөнгүй дарж өгнө. Хээний байрлал, хэд дэх өнгийг оёж байгаагаас шалтгаалан зүү ороохдоо нар зөв мөн нар буруу ороож оёдог.</p>
4		<p>Дараа нь зүүгээ дээш нь гүйцэт татаж, ороосон утасныхаа дээд талыг даруулж оёно. Үүнийг зураг дээр тасархай зураасаар зурж үзүүлэв.</p>
5		<p>Зүү ороогоод харахад утсан тойрог дүрс бий болсон байх ба даруулж оёсны дараа ороох утсаа чанга татаж болохгүй. Харин даруулж оёх утсаа жигд татаж, цэвэрхэн оёх нь чухал. Дараа нь адил хэмжээтэй тойрог үүсэх зайд зүүгээ араас нь дээш хагас гаргана. Зөвхөн энэ үед эрхий хуруугаараа дарахаа болино.</p>
6		<p>Ороох утсаа таталгүй, зүүгээ нямбай орооно. Анхнаасаа зүүгээ нар зөв ороосон бол цаашид нар зөв ороож оёно. Нар буруу ороосон бол мөн тэр ороолтоороо дүрсээ оёж дуусаад дараагийн өнгө хаанаас эхлэхээс шалтгаалан ороолтны чиг өөр өөр байна. Заавал нар зөв ороодог гэсэн ойлголт байхгүй ээ. Эхлэх үзүүр, өнгийн дагнаасны хэддэх өнгө зэргээс шалтгаалан зүү ороох чигээ зөв сонгоорой.</p>

7		<p>Зүүгээ татаж эхний тойргийн төв рүү доош нь хатгана. Зураг дээр эхлэн сураглцагсдад тохируулан ороох утас, шаглах утсаа өөр өөр өнгөөр үзүүлсэн бөгөөд даалин оёхоор хээ угалзаа буулган оёж эхлэх гэж байгаа бол ижил өнгийн утсаар ороож, даруулдаг гэдгийг анхаараарай.</p>
8		<p>Дахин адил хэмжээтэй цагираг тойрог үүсгэх зайд зүүгээ дороос дээш хатгаж орхино.</p>
9		<p>Эрхий хуруугаараа ороосон утсаа дарж өмнөх цагариг тойргийн голд нь доош хатгаж даруулж оёх замаар зүү ороох оёдол үргэлжилнэ.</p>

Хөөмөлтэй зүү ороох оёдол

Хөөмөлтэй зүү ороох оёдол нь өнгийн дагнаас гарган зүү ороох оёдлоос өргөн, товгор, биетэй болдог. Мөн 2 утас 1 зүүгээр оёно. Олон жижиг сүлжээ бүхий хээ угалзыг оёход 2 зүү хэрэглэж болно. Учир нь оёж байтал хээ угалзны сүлжээ гарч ирвэл дээд талын утсаа доош хатган сүлжээний нөгөө талаас гаргаж ирнэ. Өнгийн дагнаас гарган зүү ороох оёдолыг 3-5 өнгийн утсаар оёдог бол хөөмөлтэй зүү ороох оёдолыг нэг өнгийн утсаар оёно.

1. Хөөмөлтэй зүү ороох оёдлоор хээ угалз оёхдоо эхлээд ямар эд юмсын хаана нь хээ оёхоо сонгож, эсгээд, нимгэн материал дээр оёх бол цаваг наана.
2. Хээ угалзаа зузаан цэмбэн дээр оёх бол зургаа шивүүрийн аргаар буулгана. Торгон дээр оёх арга өмнөх зүү ороох оёдолтой адилхан аргаар хээгээ буулгана.
3. Буулгасан зургаа тодруулж харандаагаар зурна.
4. Зурсан хээ угалзны дагуу хөөмөл гэж нэрлэгдэх бүдүүн утас даруулж оёно.
5. Оёсон бүдүүн утсан дээгүүрээ зүү ороох оёдлоо хоёр талд нь ээлжлэн хатгах маягаар оёно. [14]

Эрхээмэл хатгамал хийх урлаг

Эрхээмэл гэдэг бол зүү ороож оёдог хатгамал юм. Эхлээд хийх зүйлийнхээ зургийг зураад шивж, хийх торгон дээрээ цагаан нунтаг юмаар цохино. Цохисон дээгүүрээ зургаа будаггүй зүйлээр цэвэрхэн зураад юу хийх байна түүнийхээ хэв хэлбэрээр дагуулан зүү ороож оёно. Жишээ нь дагнаастай хээ угалз хийлээ гэхэд хичнээн өнгийн утсаар хийх байна түүнийхээ тоог 1мм-ээр бодож хээ угалзны өргөнийг зурна. Энэ зурган дээрээ зурахдаа хамгийн тод өнгөнөөс нь барьж дотор талын зурган дээгүүр оёно. Энэ утсыг оёхдоо зургийн адил тохирсон өнгөөр их сайн утсаар хянамжтай оёх хэрэгтэй. Үүнээс гаднах өнгө нь дотор утас руугаа шахаж оёдог учир хэв хэлбэр эвдэгдэхгүй харин угалзны дотор талын өнгө нь хар хөх байвал түүний гадны талын өнгө нь хөх цэнхэр цагаан гэх мэт дагуулж оёно. Энэ эрхээмэлээр уг зурагны өнгийг сайн олсон болоод утасны өнгө зургийн өнгөтэй тохирч байгаа бол ямарч зүйлийг оёж болдог юм. Шууд хатгамалыг эрчгүй утсаар оёх нь сайн байдаг, үүнийг зураг бол тосон будгийн зураг шиг олон өнгийн давхарлаж хольсон байж болно. Энэ хатгамалыг давхарлаж, хольж оёдог учир зураг шиг өнгөтэй болгож болно. Энэ хатгамалыг хатгахдаа хатгах зүйлийн дэвсгэрийг жаазанд сайн тэлж хадаад түүн дээрээ хийх зүйлийнхээ зургийг зураад зурсан дээрээ дэвсгэр хийх өнгийн утсаар нэг тийш нь ширхэгийг нь нийлүүлэн ташуу хатгана. Үүнд дээрээ гэрэл сүүдрийн өнгөөр давхарлан түрүүчийн хатгасан хоёр утасны хооронд хатгаж утасны өнгийг дараалуулан чангаруулсаар хатгаж оёно. Үүгээр хүн мал, цэцэг навч, уул ус зэргийг хатгахад тохиромжтой байдаг нарийн дагнаастай хээ угалзыг хийхэд тохиромж муутай байдаг. Энэ хатгамалаар юу ч хатгасан болно. Энийг хатгахад зураачийн арга маш их шаардагдах болно. Энэ хоёр хатгамалаас өөр хонин холбоо, хэрээсэн хатгамал зэрэг янз бүрийн хатгамалууд байна. [15]

Зүү ороох оёдлоор манай өвөг дээдсээс олон үеийг дамжин, өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн бөгөөд 1980-аад оноос ерөнхий боловсролын сургуулийн тавдугаар ангийн технологийн хичээлийн агуулгад зүү ороох оёдол байхаас гадна ахлах ангид энэ урлах аргыг заадаг болсон байна.

IV. ДҮГНЭЛТ

Ардын урлагийн бүтээл болох даалин урлал нь нэг талаасаа хэрэгцээг хангах, нөгөө талаараа өөртөө шингэсэн гоо сайхны хэрэгцээ /эстетичность/, ертөнцийг үзэх үзлээрээ хүнийг хүмүүжүүлэх, ёс зүйд суралцуулах хосолмол шинжтэй. Бусдаас ялгарах өвөрмөц хэлбэр бүхий даалинг энгийн хэрэглээнд оруулж чадсан монголчуудын уран сайхны сэтгэлгээ нь зан заншлын хувьд асар том байр суурь эзэлдэг гар урлал юм.

Бусад бүх төрлийн хатгамлыг машинаар оёж болдог. Хөөрөгний даалинг зүү ороосон гогцоо гаргаж шагладаг учраас машинаар оёх боломжгүй. Тиймээс зүү ороох энэ оёдол бол монголчуудын соёлын нэгэн өв юм.

Сүүлийн жилүүдэд хүмүүс өв соёлоо мэддэг болж бас уран хатгамалчид ч гэсэн тодорхой хэмжээгээр түгээн дэлгэрүүлж, таниулж байгаа учраас даалин, хавтага гэх мэт ахуйн хэрэгцээний гар урлалыг сонирхогчид олширсоор байгаа билээ.

Уран хатгамалч багш нар өөрсдийн гаргасан номондоо шинээр хээ зохиож оруулсан байна. Эдгээр номнууд нь даалин хийж байгаа хүмүүст бэлдэц болон ашиглагдаж байна. Уран хатгамалчид улам гоё, улам сонирхолтой хээ угалз, оёо хатгаас гаргахыг хичээх болжээ.

Энэ их өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, хөгжүүлэх үүргийг хэн хүнгүй ойлгож, ажил хэрэг болгож, түгээн дэлгэрүүлэх зайлшгүй шаардлага байна. Монгол гар урлалыг зөвхөн бэлэг дурсгалын зүйл хийхээр төсөөлж, арилжааны хэлбэрээр хөгжүүлж, зөвхөн гадны жуулчдад таниулах зорилгоор ажиллах нь өрөөсгөл ойлголт юм. Харин үндэсний гар урлалыг орчин үеийн шинэлэг санаагаар баяжуулан уламжлалт шинж чанарыг нь алдагдуулалгүй хөгжүүлвэл зохино.

НОМ ЗҮЙ

- 1 *З.Цэнгэлсайхан “Эгнэшгүй санаа” ТББ-ын тэргүүн. Ярилцлага. З.Цэнгэлсайхан. Уран хатгамал Embroidery УБ., 2005 он*
- 2 *Эмма Кенни. World Mental Health Day. www.crewelwork.com*
- 3 *Ц.Санжаасүрэн. Эртний түүхийн дээжис бичиг., 1985 он.*
- 4 *Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх. 131-р тал.*
- 5 *БНМАУ-ын түүх. 281-р тал.*
- 6 *Монгол үндэстний хувцас засал. Өвөрмонголын Лионин хот. 1997 он.*
- 7 *Ч.Солонго. Монголчуудын үйл урлахуйн эрдэм ухаан УБ., 1999 он*
- 8 *Б.Жаргалмаа Ардын урлал, гар үйлдвэрлэл /2015.03.06/*
- 9 *Ц.Батсайхан. Хөөрөгний ертөнц УБ., 2018 он*
- 10 *Ц.Батбуян, Ц. Бямбацэрэн. Хөөрөгний даалин оёх арга 2014 он.*
- 11 *Х.Ариун-Эрдэнэ, О.Ширчинжав. Хөөрөгний тухай өгүүлэхүй УБ., 2003 он*
- 12 *Д.Баярсайхан. Ардын урлалын тухай тэмдэглэл УБ, МУЭХ., 1988 он*
- 13 *О.Өнөрмаа. Уран хатгамал УБ., 1984 он*
- 14 *Д.Гэвшээхүү Монгол ардын гар урлалын уламжлалт арга, 1970 он*
- 15 *Н.Цэцгээ, Н. Норолхоо. Үйлчлэх хөдөлмөр 4-6 анги., 1976 он*